



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.12.06 № 15-134-12/4484
танай _____-ны № _____-т

Тодруулгад хариу өгөх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/202401011292 дугаартай “Барилга байгууламжийн дахин үнэлгээ, нөөцийн тооцоолол хийх ажил +”-ын тендерт оролцохыг сонирхогчдоос Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

Хавсралт 1 хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407038745

1. Эрдэнэт үйлдвэрийн барилга байгууламжийн дахин үнэлгээг хийх ажил нь газар дээрх биет үзлэгээр эхлэнэ. Энэ ажил нь талбар дээр нэлээд олон хоног зарцуулах магадлалтай гэж бид үзэж байна. Иймд Захиалагч тал нь мэргэжилтнүүдийг байрлах байраар хангах уу?

Хариулт: Байраар хангахгүй, энэ зардал нь ажлын хөлсөнд орсон байгаа болно.

2. Барилга, байгууламжийн жагсаалтыг харвал БНХАУ болон ОХУ–д байрлалтай үл хөдлөх хөрөнгүүд байна. Тус хөрөнгүүдийн биет үзлэгийг заавал очиж үзэх замаар үнэлгээ хийхийг Аудитор нь шаардаж байгаа юу? Тийм бол томилолтын зардал, тус улсад байрлах байраар хангана гэж таамаглаж байна. Энэ таамаглалтай санал нэг байна уу?

Хариулт: Үнэлгээний олон улсын стандартын дагуу биетээр очиж үзэж, хэмжилт хийхийг шаардана. Томилолт, байрны зардлыг үйлдвэрийн газар хариуцахгүй.

3. Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь Захиалагч талаас үнэлгээ тогтооход шаардлагатай мэдээлэл, баримт материалын бүрдүүлэлтийг бүрэн болгохоос ихээхэн хамаардаг. Мөн томоохон үл хөдлөх хөрөнгө – барилгын хувьд барилгын төсөв хийх шаардлага тавигдах магадлалтай учраас ажил гүйцэтгэж дуусах хугацаа уртсахаар харагдаж байна. Дээрх нөхцлүүдээс хамааран ажил гүйцэтгэх хугацаандаа ажлыг дуусгаж амжихгүй байх магадлалтай байх тул ажил гүйцэтгэж дуусах хугацааг хойшлуулах нөхцөлийг зөвшөөрөх үү? Үгүй бол бид энэ эрсдэлийг тооцоолж үнээ тогтоох шаардлага гарна.

Хариулт: Хугацаа сунгах асуудлыг үйлдвэрийн газрын удирдлагын түвшинд тухай бүрд нь ярилцаад шийдвэрлэх боломжтой.

4. Энэ ажлын даалгавар, цар хүрээг харвал нийт санхүүжүүлэх дүнгээс хэтрэх магадлалтай байна. Санхүүжүүлэх дүнгээс давсан санал өгөхийг зөвшөөрөх эсэх?

Хариулт: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.10 дахь хэсэгт заасны дагуу тендерийн үнэ төсөвт өртгөөс хэтэрсэн бол тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

5. Энэ ажлын даалгавар нь өргөн цар хүрээтэй байгаа ба бид ажиллах хүчний нөөц бололцоогоо нарийн хуваарилж төлөвлөгөө гаргах шаардлагатай байгаа тул барилга байгууламж бүлгийн хөрөнгийн жагсаалтыг тус жагсаалт дээр ажиллах боломжтой хувилбараар буюу microsoft office – ийн excel байдлаар манай байгууллагын үнэлгээний менежер Э. Цацралын tsatsral@bdo.mn хаяг руу ирүүлэх боломжтой бол ирүүлнэ үү?

Хариулт: Файлыг хавсаргав.